



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА 2018



Улаанбаатар хот
2019 он



ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

М.Батхишиг

ЧД-ын Статистикийн хэлтийн ахлах
мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот

Утас: 70113013

70130767

70110767

976-11-310767

Цахим хуудас: www.ubstat.mn

www.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn



ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг 2009 он хүртэл анхан шатны нэгж болох баг, хорооноос мэдээлдэг “Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан”-гийн дүнгээр гаргаж байсан.

Хүн амын ажил эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний Статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд шинэчлэн баталсан. Одоогийн байдлаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс тооцон гаргаж байна.

Ажиллах хүчний судалгаанд баг, хороодоос түүврээр сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж, үр дүнг гаргадаг.

Ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцоход 2018 онд улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 1358637 байгаагийн 555347 (40.9%) нь Улаанбаатар хотод, 55510 (4.1%) нь Чингэлтэй дүүрэгт байна.

Хүснэгт 1. Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт


Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Нийт хүн ам	154 819	158 014	159 051	157 258
15 ба түүнээс дээш насны нийт хүн ам	110 202	112 487	109 212	109 547
Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны хүн ам	104 660	106 755	102 924	103 275
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	52 206	51 864	52 259	55 510
Үүнээс: Ажиллагчид	46 644	44 355	43 600	47 978
Ажилгүй иргэд	5 562	7 509	8 659	7 532
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	52 454	54 891	50 665	47 765
Ажиллах хүчний оролцооны түвшин	49.9	48.6	50.8	53.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	44.6	41.5	42.4	46.5
Ажилгүйдлийн түвшин	10.7	14.5	16.6	13.6

Хүснэгт 2. Дүүргийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Нийт хүн ам	79 914	81 754	82 653	80 779
15 ба түүнээс дээш насны нийт хүн ам	58 802	58 051	59 551	57 593
Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны хүн ам	55 772	57 324	57 288	55 696
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	24316	24 620	23 843	25 496
Үүнээс: Ажиллагчид	22134	22 115	21 117	22 859
Ажилгүй иргэд	2182	2 505	2 726	2 637
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	31 456	32 704	32 446	30 200
Ажиллах хүчний оролцооны түвшин	79.5	42.9	41.6	45.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	39.7	38.6	36.9	41.0
Ажилгүйдлийн түвшин	50.1	10.2	11.4	10.3

Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 53.7 хувьтай байна. Ажиллах хүчний судалгааны тооцоогоор эдийн засгийн идэвхтэй хүн ам 55510 байгаагаас 86.4 хувь нь ажиллагчид, 13.6 хувь нь ажилгүй иргэд байна.

Зураг 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт



Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагсдын тоо 2018 онд 47978 болж өмнөх оноос 10.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Ажиллагчдын тоо, дүүргээр

Засаг захиргаа	2015	2016	2017	2018
Улсын дүн	1 151 223	1 147 843	1 238 333	1 253 023
Нийслэлийн дүн	459 971	465 091	512 189	513 053
Багануур, Багахангай	10 303	9 240	9 404	8 945
Баянгол	71 626	72 082	78 942	78 421
Баянзүрх	109 583	125 044	148 491	140 347
Налайх	14 614	13 840	12 559	14 425
Сонгинохайрхан	107 105	104 512	110 450	111 318
Сүхбаатар	46 778	40 530	48 255	51 066
Хан-Уул	53 318	55 488	60 488	60 556
Чингэлтэй	46 644	44 355	43 600	47 978

Ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцоход 2018 онд улсын хэмжээнд 1253023 ажиллагчид байгаагийн 513053 (40.9%) нь Улаанбаатар хотод, 47978 (3.8%) нь Чингэлтэй дүүрэгт байна.

Нийт ажиллагчдын 25.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 15.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 11.7 хувь нь барилгын, 7.1 хувь нь боловсролын, 6.8 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 6.6 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалах салбарын аж ахуй нэгж, байгууллагуудад ажиллаж байна.

Хүснэгт 4. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2015	2016	2017	2018	Үүнээс	
					Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллагчид бүгд	46 644	44 355	43 600	47 978	25 119	22 859
Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	68	479	320	0	0	0
Уул уурхай, олборлолт	1 252	923	2 015	2 019	1 789	230
Боловсруулах үйлдвэрлэл	5 997	4 488	5 155	7 547	3 827	3 720
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	440	839	693	657	356	301
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	298	610	170	155	78	77
Барилга	6 666	5 051	3 516	5 592	4 656	936
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	10 059	9 370	10 714	12 113	5 853	6 260
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3 398	3 302	2 832	3 242	2 604	638
Зочид бүүдал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2 565	3 255	3 041	2 553	729	1 824
Мэдээлэл, холбоо	1 355	1 441	930	687	388	299
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1 403	1 099	754	765	242	523
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	116	157	140	0	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	876	591	614	521	77	444
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1 188	1 098	1 389	790	505	285
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	3 815	3 749	3 361	3 179	1 915	1 264
Боловсрол	3 287	4 542	4 296	3 414	433	2 981
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1 912	1 720	1 464	1 897	238	1 659
Урлаг, үзвэр, тоглоом наадам	704	992	428	1 289	595	694
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1 158	649	1 682	1 343	763	580
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0	0	0	76	0	76
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	87	0	88	139	71	68

Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшинг тооцсоноор хүн амын хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, хөдөлгөөн насны бүлгээр хэрхэн өөрчлөгдөж байгааг харих боломжтой.

Ажиллах хүчний оролцооны түвшин нийслэлд 45-49 насанд хамгийн өндөр 78.2 хувь байгаа бол дүүрэгт 35-39 насанд 80.1 хувь байна. Мөн 35-39 насны эрэгтэйчүүдийн оролцооны түвшин хамгийн өндөр 92.5 хувь, эмэгтэйчүүд 68.9 хувьтай байна.

Хүснэгт 5. 15-59 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, байршил, хүйсээр

Насны бүлэг	Нийслэл			Дүүрэг		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15-19 нас	7.5	12.2	2.9	8.5	11.4	5.2
20-24 нас	42.8	48.6	37.3	48.0	51.6	44.9
25-29 нас	67.0	85.1	51.5	70.4	86.5	57.1
30-34 нас	76.2	92.9	61.4	72.9	87.4	60.7
35-39 нас	76.9	89.2	66.7	80.1	92.5	68.9
40-44 нас	77.5	85.6	70.3	72.7	81.5	65.6
45-49 нас	78.2	83.8	73.3	73.4	84.3	63.5
50-54 нас	63.9	71.7	58.0	65.9	73.2	59.9
55-59 нас	37.3	52.6	24.6	39.1	61.9	20.8
Дүүргийн Дундаж	58.6	69.1	49.5	59.0	70.0	49.6

Түүвэр судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдын 25.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 15.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.7 хувь нь барилгын салбарт ажиллаж байна. 7.1 хувь нь боловсролын салбарт, 6.8 хувь нь тээвэр ба агуулахын салбарт, 6.6 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах салбарт, 5.3 хувь нь зочид буудал, зоогийн газрын салбарт, 4.2 хувь нь уул уурхай, олборлох салбарт, 4.0 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 2.8 хувь нь үйлчилгээний бусад салбарт, 2.7 хувь нь урлаг, үзвэр, тоглоомын салбарт, үлдсэн 7.9 хувь нь бусад салбарт ажиллаж байна.

Зураг 2. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хүйсээр,




Ажилгүй иргэдийн тоог ажиллах хүчний тоонд харьцуулан тооцсон ажилгүйдлийн түвшин 13.6 хувь болж өмнөх оноос 3.0 пунктээр буурсан байна. Ажилгүй иргэн гэдэг нь тухайн хугацаанд ажилгүй байсан боловч ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Хүснэгт 6. Ажилгүй иргэдийн тоо, дүүргээр

Засаг захиргаа	2015	2016	2017	2018
Улсын дүн	92 672	127 807	119 092	105 614
Нийслэлийн дүн	34 135	46 418	41 388	42 294
Багануур, Багахангай	516	340	205	1 320
Баянгол	6 161	8 716	4 919	4 201
Баянзүрх	6 983	7 732	11 246	8 091
Налайх	2 309	1 531	1 317	1 325
Сонгинохайрхан	6 840	10 674	4 309	12 291
Сүхбаатар	2 084	4 159	3 671	3 166
Хан-Уул	3 680	5 757	7 062	4 368
Чингэлтэй	5 562	7 509	8 659	7 532

Зураг 3. Нийслэлийн ажилгүй иргэд, дүүргээр, хувиар



Улсын хэмжээнд нийт 105614 иргэн ажил идэвхтэй хайж байгаа, ажилгүй гэж бүртгэгдсэний 40.0 хувь нь Нийслэл хотын иргэд байна.

Ажилгүйдлийн түвшин 2018 онд улсын дундаж үзүүлэлт 7.8хувь, нийслэлийн дундаж 7.6 хувь, Дархан-Уул аймагт хамгийн өндөр 19.6 хувь, Төв аймагт хамгийн бага 2.6 хувь байгаа бол Чингэлтэй дүүрэгт 13.6 хувь байна.

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 35.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэдийн 28.8 хувь нь 35-44 насны иргэд хөдөлмөрийн идэр насны иргэд байна.

Хүснэгт 6. Ажилгүй иргэд, насны бүлэг, хүйсээр


Насны бүлэг	2017	2018	Үүнээс:	
			эрэгтэй	эмэгтэй
Нийт дүн	8 659	7 532	4 895	2 637
15 – 19 нас	141	576	504	72
20 – 24 нас	976	1 247	862	385
25 – 29 нас	2 427	816	494	322
30 – 34 нас	1 307	543	319	224
35 – 39 нас	1 131	1 131	447	684
40 – 44 нас	733	1 040	827	213
45 – 49 нас	779	922	572	350
50 – 54 нас	958	813	498	315
55 – 59 нас	207	444	372	72

Дүүргийн 15, түүнээс дээш насны хүн амын 43.6 хувийг эдийн засгийн идэвхгүй хүн ам эзэлж байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг шалтгаанаар авч үзвэл 29.0 хувь нь суралцдаг, 27.8 хувь нь тэтгэвэрт гарсан, 15.7 хувь нь хүүхэд асардаг, 10.3 хувь нь гэрийн ажилтай, 7.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 2.8 хувь нь бусад, 2.1 хувь нь өвчтэй байсан, 1.7 хувь нь өвчтөн, өндөр настан асардаг, мөн 1.7 хувь нь ажил хийх хүсэлгүй, 1.1 хувь нь сурахаар явж байгаа, 0.6 хувь нь өндөр настайн улмаас ажил хөдөлмөр эрхэлдэггүй байна.

Хүснэгт 7. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар

Ажил эрхэлдэггүй шалтгаан	2017	2018
Нийт дүн	50 665	47 765
Гэрийн ажилтай	3 053	4 943
Суралцдаг	13 209	13 855
Сурахаар явах гэж байгаа	356	505
Тэтгэвэрт	16 741	13 267
Өндөр настан	423	265
Хөгжлийн бэрхшээлтэй	3 492	3 452
Ажил хийхийг хүсээгүй	423	831
Хүүхэд асарсан	7 768	7 477
Өвчтэй байсан	1 718	1 006
Өвчтөн, өндөр настан асарсан	515	827
Бусад	2 967	1 335

Зураг 4. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар, хувиар



ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-2018



АЖИЛЛАГЧИД, статусаар

- 70.5% ЦАЛИН ХӨЛСТЭЙ АЖИЛЛАГЧ
- 23.2% ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ
- 3.0% ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД ЦАЛИН ХӨЛСГҮЙ ОРОЛЦОГЧ
- 2.4% АЖИЛ ОЛГОГЧ,
- 0.9% НӨХӨРЛӨЛ ХОРШООНЫ ГИШҮҮН

ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ, шалтгаанаар

ГЭРИЙН АЖИЛТАЙ
10.3%



СУРАХААР ЯВАХ ГЭЖ БАЙГАА
1.1%



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
7.2%



ХҮҮХДЭЭ АСАРСАН
15.7%



БУСАД ШАЛТГААНТАЙ
4.5%



СУРАЛЦДАГ
29%



ТЭТГЭВЭРТ ГАРСАН
28.4%



АЖИЛЛАХ СОНИРХОЛГУЙ
1.7%



ӨВЧТЭЙ БАЙСАН
2.1%

